



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/118

Суугаант

Ж.Цэцэгдэлгэрт хариуцлага тооцох тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1; 29 дүгээр зүйлийн 29.2.2 дэх заалт, 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 05/10051 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг: Сургуулийн захирал ажилтай Ж.Цэцэгдэлгэр нь албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд энэ тухайгаа бичгээр мэдээгүй зөрчил дутагдал гаргасан тул албан тушаалын цалинг 30 хувиар бууруулсугай.

Хоёр: Ж.Цэцэгдэлгэрийн үндсэн цалинг 1 сарын хугацаатай 30 хувиар бууруулж тооцон олгохыг Боловсрол соёлын Нягтлан бодогч (Б.Энх-Амгалан)-д зөвшөөрсүгэй.

Гурав: Албан үүргээ гүйцэтгэхдээ хуулийн дагуу дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг Сургуулийн захирал (Ж.Цэцэгдэлгэр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Л.ӨЛЗИЙБАТ

